



ИНД-92

Иргэний Нисэхийн Багц Дүрэм

Аюултай бараа тээвэрлэх

Иргэний нисэхийн ерөнхий газар

ДҮРМИЙН ТАЙЛБАР

ИНД-92 нь аюултай барааг агаараар тээвэрлэхэд тавих шаардлагыг тогтооно.

ИНД-92 нь дараах эд зүйл, эсхүл бодист хамаарахгүй:

- Техникийн зааварчилгааны Бүлэг 1-ийн дагуу тусгайлан хасагдсан;
- Нислэгт тэнцэх чадварын, эсхүл ИНД-ийн үйл ажиллагааны шаардлагын дагуу агаарын хөлөгт байхыг шаардсан;
- Үйл ажиллагааны тусгай шаардлагыг хангах зорилгоор Дарга зөвшөөрсөн.

Энэ дүрэм нь Иргэний нисэхийн асуудал эрхэлсэн Сайдын баталсан ИНД-92-ийн цахим хувилбар бөгөөд зөвхөн ишлэл хийх зорилгоор хэрэглэнэ. Хүчин төгөлдөр ИНД-92, түүний нэмэлт, өөрчлөлтийн хуулбарыг ИНЕГ-аас, эсхүл www.mcaa.gov.mn веб сайтаас татаж авах боломжтой.

Мэдээлэл

Гишүүн улсуудын иргэний нисэхийн дүрмийг сайжруулах замаар иргэний нисэхийн салбарт нэгдсэн нэг дүрмийн зохицуулалтад шилжих Олон улсын иргэний нисэхийн байгууллага (ICAO)-ын 1992 оны 29-р чуулганы А29-3 тогтоолыг хэрэгжүүлэх зорилгоор, Монгол Улс болон Шинэ Зеланд улсын ИНЕГ-ын хооронд 1999 оны 05 сарын 06-нд байгуулсан “Техникийн Хамтын Ажиллагааны Санамж Бичиг”-ийг үндэслэн Монгол Улсын Иргэний нисэхийн багц дүрмийг боловсруулсан.

Өөрчлөлтийн түүх**Хүчин төгөлдөр огноо**

Анхны боловсруулалт

2002 оны 03 сарын 01

Нэмэлт, өөрчлөлт 1

2008 оны 02 сарын 29

Нэмэлт, өөрчлөлт 2

2009 оны 09 сарын 16

Нэмэлт, өөрчлөлт 3

2010 оны 05 сарын 07

Нэмэлт, өөрчлөлт 4 (Шинэчлэлт)

... оны ... сарын ...

Тэмдэглэл: ИНД-92-ийн шинэчлэлтийг англи болон монгол хэл дээр, NZ Part 92 Amend.2-д үндэслэн боловсруулсан болно.

ГАРЧИГ

А Бүлэг — Ерөнхий Зүйл	5
92.1. Зорилго	5
92.3. Тодорхойлолт	5
92.5. Нөөц	6
92.7. Тээвэрлэлтийн ерөнхий шаардлага	6
92.9. Хориглосон аюултай бараа	7
92.11. Үл хамаарал	7
92.13. Нисэх багийн гишүүд, эсхүл зорчигч	8
92.15. Барааг тээвэрлэлтэд санал болгох	8
92.17. Аюултай барааг саатуулах	9
В Бүлэг — Баглаа Боодол, Савлагаа, Тэмдэглэгээ Болон Шошго	9
92.51. Баглаа боодолд тавих шаардлага	9
92.53. Баглаа боодлын зөвшөөрөл	9
92.55. Савлагаанд тавих шаардлага	10
92.57. Тэмдэглэгээнд тавих шаардлага	10
92.59. Шошгонд тавих шаардлага	10
С Бүлэг — Аюултай барааг тээвэрлэлтэд санал болгох	11
92.101. Хамрах хүрээ	11
92.103. Аюултай барааг тээвэрлэлтэд санал болгох	11
92.105. Аюултай барааны тээврийн баримт бичиг	11
Д Бүлэг — Үйл ажиллагаа эрхлэгч	12
92.151. Хамрах хүрээ	12
92.153. Аюултай бараа хүлээн авах	12
92.155. Хүлээн авах шалгалт	12
92.157. Агаарын хөлөгт ачаалах хязгаарлалт	13
92.159. Хоорондоо үл зохицох аюултай бараа	14
92.161. Ялгах, тусгаарлах, аюулгүй байдлыг хамгаалах	14
92.163. Ачаалах үеийн хяналт	14
92.165. Буулгах үеийн хяналт	14
92.167. Гэмтэл, эсхүл бохирдлыг цэвэрлэх	15
92.169. Халдварт бодис	15
92.171. Цацраг идэвхт материал	15
92.173. Хөлгийн даргыг мэдээллээр хангах	15
92.175. Ажилтныг мэдээллээр хангах	16
92.177. Бараа хүлээн авах байрлалын мэдээлэл	16
92.179. Зорчигчийг мэдээллээр хангах	16
92.181. Үйл ажиллагаа эрхлэгчээр саатуулагдах	17
Е Бүлэг — Сургалт	17
92.201. Хамрах хүрээ	17
92.203. Аюултай барааны сургалтын хөтөлбөр	17
92.205. Давтан сургалт	18
92.207. Ажилтны хувийн хэрэг	18
Хавсралт А — Аюултай барааны сургалтын хөтөлбөр	20

А Бүлэг — Ерөнхий Зүйл

92.1. Зорилго

- (a) Энэ Дүрэм нь аюултай барааг агаараар тээвэрлэхэд тавих шаардлагыг тогтооно.
- (b) Энэ Дүрэм нь дараах эд зүйл, эсхүл бодист хамаарахгүй:
- (1) Техникийн зааварчилгааны 1-р Бүлгийн дагуу тусгайлан хасагдсан;
 - (2) нислэгт тэнцэх чадварын, эсхүл ИНД-ийн үйл ажиллагааны шаардлагын дагуу агаарын хөлөгт байхыг шаардсан;
 - (3) үйл ажиллагааны тусгай шаардлагыг хангах зорилгоор Даргын зөвшөөрсөн.
- (c) Энэ зүйлийн (b)(2) болон (3)-т хамаарах эд зүйл, эсхүл бодисыг солиход зориулагдсан эд зүйл болон бодисыг, үйл ажиллагаа эрхлэгч Техникийн зааварчилгааны Бүлэг 1-ийн Хэсэг 2.2-ын дагуу илгээснээс бусад тохиолдолд, энэ Дүрмийн дагуу тээвэрлэсэн байх ёстой.

92.3. Тодорхойлолт

Энэ дүрэмд:

Агуулах сав гэж битүүмжлэх аливаа хэлбэрийг багтаасан бодис, эсхүл эд зүйлсийг хүлээн авч, хадгалах хадгалалтын савыг;

Ачааны агаарын хөлөг гэж зорчигч тээвэрлэдэг агаарын хөлгөөс бусад бараа, эсхүл эд зүйлс тээвэрлэж байгаа агаарын хөлгийг;

Ачааны оноосон нэр гэж тээвэрлэлтийн баримт, мэдэгдэл, болон баглаа боодол бүрт байгаа тухайн эд зүйл, эсхүл бодисыг тодорхойлоход хэрэглэдэг нэрийг;

Ачих нэгж төхөөрөмж гэж дараахаас бусад ачааны болон агаарын хөлгийн чингэлэг, агаарын хөлгийн тортой ачааны тавцан, эсхүл агаарын хөлгийн даруулгатай, тортой тавцанг:

- (1) гадуур баглаа боодол; эсхүл
- (2) цацраг идэвхт материалын ачааны чингэлэг.

Аюултай барааны ангилал (Ангилал 1-ээс 9 хүртэл) гэж Техникийн зааварчилгааны Бүлэг 2-т заасан ангиллыг;

Баглаа боодол гэж Чикагогийн конвенцийн Хавсралт 18-ийн савлагааны шаардлагын хэрэгжилтийг бататгах болон агуулах сав өөрийн хадгалалтын үүргээ гүйцэтгэхэд шаардлагатай хадгалах сав болон аливаа бүрэлдэхүүн хэсгийг;

Багц гэж түүний агууламжийг тээвэрлэлтэд бэлдсэн баглаа боодлоос бүрдсэн савлах үйл ажиллагааны эцсийн бүтээгдэхүүнийг;

Гадуур баглаа боодол гэж зөөх, хадгалах, тээвэрлэхэд тохиромжтой нэг тээвэрлэлтийн нэгжийг бүрдүүлдэг ба нэг, эсхүл олон багцыг багтаахад хэрэглэдэг хадгалах савыг;

Зөвшөөрөгдсөн гүйцэтгэгч гэж онц аюултай бодисыг зохицуулах тусгай зөвшөөрөлтэй этгээдийг. Зөвшөөрөгдсөн гүйцэтгэгчийн гэрчилгээг сорилтын гэрчилгээжүүлэгч олгох ба 5 жилийн хугацаанд хүчинтэй байна.

Илгээх бараа гэж нэг илгээгчээс нэг цагт, нэг хаягаар нэг авалтаар авсан ба нэг хүлээн авагчид нэг хаягаар хүргэгдэх үйл ажиллагаа эрхлэгчийн хүлээн авсан нэг, эсхүл түүнээс олон багц аюултай барааг;

Нэгдсэн үндэстний дугаар гэж бодис, эсхүл тодорхой бүлгийн бодисыг ангилан тогтоох зорилгоор Нэгдсэн Үндэстний Байгууллагын Аюултай бараа Тээвэрлэлтийн Экспертүүдийн хорооны тогтоосон 4 оронтой тоог;

Савлагаа гэж эд зүйл, эсхүл бодисыг ороож хайрцаглах, баглаа боодолд хийж битүүмжлэх, эсхүл бусад аливаа хэлбэрээр аюулгүй болгох чадварлаг үйл ажиллагааг;

Тогтмол илгээгч гэж дараах аливаа этгээдийг:

- (1) аюултай барааг үйлдвэрлэгч, эсхүл ханган нийлүүлэгч болон аюултай барааг агаараар тээвэрлэхийг санал болгож буй; эсхүл
- (2) олон нийтэд аюултай барааг агаараар тээвэрлэх саналыг зохион байгуулах үйлчилгээ үзүүлдэг;

Үйл ажиллагаа эрхлэгч гэж агаарын хөлгийн үйл ажиллагаанд оролцож байгаа, эсхүл оролцохоор санал болгож буй этгээдийг;

Үйлчилгээний агент гэж зорчигч, эсхүл ачааг хүлээн авах, ачаалах, буулгах, шилжүүлэх, эсхүл бусад үйл ажиллагааг багтаасан тухайн үйл ажиллагаа эрхлэгчийн өмнөөс зарим, эсхүл бүх үйл ажиллагааг гүйцэтгэдэг байгууллагыг;

Шуудангийн эд зүйл гэж захидал, илгээмж, эсхүл дараахийг багтаасан шуудангаар илгээгдсэн болон хүргэгдээгүй бусад эд зүйл:

- (1) хүргэгдсэн боловч, хүлээн авагчийн гарт очоогүй эд зүйл;
- (2) аливаа захиа, илгээмж, эсхүл эд зүйлийн агууламж;

92.5. Нөөц

92.7. Тээвэрлэлтийн ерөнхий шаардлага

(a) Аюултай бараа нь Техникийн зааварчилгааны дагуу ангилагдсан, баримтжуулсан, гэрчилгээжсэн, **тодорхойлогдсон**, багцалсан, зохих тэмдэглэгээ болон шошго тавьсан болон Техникийн зааварчилгаанд заасан илгээх нөхцөлийг хангаснаас бусад тохиолдолд, аливаа этгээдийг агаараар аюултай бараа тээвэрлэхийг санал болгох, эсхүл хүлээн авахыг хориглоно.

(b) Аюултай барааг Техникийн зааварчилгаа, эсхүл энэ Дүрмийн шаардлагын дагуу хүлээн авсан, тээвэрлэлтэд бэлтгэсэн болон тээвэрлэснээс бусад тохиолдолд, аливаа этгээдийг аюултай бараа агаараар тээвэрлэхийг хориглоно.

92.9. Хориглосон аюултай бараа

(a) Хэрэв тухайн аюултай барааг Техникийн зааварчилгааны дагуу агаараар тээвэрлэхийг хориглосон бол, энэ зүйлийн (b)-д зааснаас бусад тохиолдолд аливаа этгээдийг агаараар аюултай бараа тээвэрлэлтэд санал болгох, эсхүл хүлээн авахыг хориглоно.

(b) Этгээд нь, Техникийн зааварчилгаанд өөрөөр тогтоогоогүй эд зүйл, эсхүл бодисыг багтаасан Аюултай барааны жагсаалтын 9 болон 10, эсхүл 11 болон 12 дах баганад хориотой гэж тодорхойлогдсон эд зүйл, эсхүл бодисыг хэрэв Дарга тээвэрлэхийг зөвшөөрсөн бол, тээвэрлэлтэд санал болгох, эсхүл хүлээн авч болно.

92.11. Үл хамаарал

(a) Хэрэв тухайн агаарын хөлөг нь зөвхөн цагдаагийн зорилгоор үйл ажиллагаа хийж байгаа бол, цагдаагийн ажилтан энэ Дүрмийг дагаж мөрдөхгүй өөрийн ажил үүргийн хүрээнд аюултай барааг тээвэрлэж болно.

(b) Аливаа этгээд нь энэ Дүрмийг дагаж мөрдөхгүй Ангилал 1-аюултай барааг агаараар тээвэрлэхэд санал болгох, эсхүл хүлээн авч болно, хэрэв:

- (1) тээвэрлэлтийг зөвшөөрөгдсөн гүйцэтгэгч зөвшөөрсөн бол;
- (2) тухайн аюултай барааг:
 - (i) зөвшөөрөгдсөн гүйцэтгэгчийн хяналтан дор тээвэрлэх бол; эсхүл
 - (ii) зөвшөөрөгдсөн гүйцэтгэгчийн өгсөн зааварчилгааны дагуу тээвэрлэх ба тухайн зөвшөөрөгдсөн гүйцэтгэгч нь аюултай барааны тээвэрлэлтийн бүх цаг хугацаанд холбогдон дэмжлэг үзүүлэхэд боломжтой байх бол;
- (3) тухайн барааг тээвэрлэх аюулгүй ажиллагааны болон онцгой нөхцөлийн журмыг тогтоосон бол;
- (4) тухайн бараа нь:
 - (i) агаараар тээвэрлэх зөв тохиромжтой нөхцөлд байгаа бол;
 - (ii) аюулгүй тээвэрлэлтэд зориулж хадгалсан ба хамгаалсан бол;
- (5) тухайн агаарын хөлгөөр тухайн нислэгийн зорилгод зайлшгүй байх хэрэгтэй зорчигчоос өөр зорчигч тээвэрлээгүй бол;
- (6) тухайн нислэг хүн ам шигүү суурьшсан хот, тосгон, эсхүл суурин газраас зайтай хийгдэх бол;

(c) Этгээд нь аюултай барааг зорчигчийн **хоббид** хэрэглэх зорилгоор, энэ Дүрмийг дагаж мөрдөхгүйгээр агаараар тээвэрлэхэд санал болгох, эсхүл хүлээн авч болно, хэрэв:

- (1) тухайн аюултай барааг дараах битүүмжлэлгүй агаарын хөлгөөр тээвэрлэх бол;
 - (i) хөөрөлтийн гэрчилгээжсэн дээд жин нь 5700 кг, эсхүл түүнээс бага;
 - (ii) орон нутгийн ИХНД / VFR –ээр үйлдэх нислэгт;

- (2) тухайн аюултай бараа нь Техникийн зааварчилгааны Аюултай барааны жагсаалтад зорчигч тээвэрлэж байгаа агаарын хөлөгт агаараар тээвэрлэх нь хориотой гэж заагдаагүй бол;
- (3) тухайн аюултай барааг тээвэрлэх аюулгүй ажиллагааны болон онцгой нөхцөлийн журмыг тогтоосон бол;
- (4) тухайн аюултай барааг нэг бүрчлэн таньж тодорхойлсон бол;
- (5) тухайн барааны аюултай шинж чанарыг хөлгийн даргад мэдэгдсэн бол;
- (6) тухайн аюултай бараа нь:
 - (i) агаараар тээвэрлэх зөв тохиромжтой нөхцөлд байгаа бол;
 - (ii) хэрэв тэдгээр нь хоорондоо аюултайгаар харилцан үйлчлэх магадлалтай бол, тусгаарлагдсан байх;
 - (iii) нислэгт гоожих, эсхүл гэмтэхээс сэргийлэх зорилгоор байрлуулсан, хамгаалсан болон хэрэв шаардлагатай бол, савлаж багласан бол;
- (7) тухайн агаарын хөлөгт зөвхөн тухайн аюултай бараатай холбоотой зорчигч тээвэрлэж байгаа бол.

92.13. Нисэх багийн гишүүд, эсхүл зорчигч

Этгээд нь Техникийн зааварчилгаанд зөвшөөрснөөс бусад тохиолдолд, агаарын хөлөгт аюултай барааг бүртгүүлсэн ачаа, эсхүл гар тээшинд, эсхүл биедээ авч орох, эсхүл бусад этгээд авч орох шалтгаан болж болохгүй.

92.15. Барааг тээвэрлэлтэд санал болгох

- (a) Аливаа эд зүйл, эсхүл бодисыг агаараар тээвэрлэхэд санал болгож буй этгээд нь:
 - (1) хэрэв тухайн эд зүйл, эсхүл бодис нь аюултай бараа биш бол, үйл ажиллагаа эрхлэгчид гарын үсэг зурсан дараах баримт бичгийг гаргаж өгнө:
 - (i) тухайн эд зүйл, эсхүл бодисыг нарийвчлан тодорхойлсон; эсхүл
 - (ii) тухайн эд зүйл, эсхүл бодис нь аюултай бараа биш гэдгийг мэдэгдсэн; эсхүл
 - (2) хэрэв тухайн эд зүйл, эсхүл бодис нь аюултай бараа бол, С Бүлгийг дагаж мөрдөнө.
- (b) Энэ зүйлийн (a)(1) заалт нь:
 - (1) шуудангийн эд зүйл, эсхүл
 - (2) бүртгүүлсэн ачаа, эсхүл гар тээшинд хамаарахгүй.

92.17. Аюултай барааг саатуулах

(a) ИНД-12-ын дагуу мэдээлсэн осол, эсхүл зөрчилтэй холбоотой, агаараар тээвэрлэхээр санал болгосон, эсхүл хүлээн авсан аюултай бараа нь Дарга **саатуулсанд** тооцогдоно.

(b) Дарга:

- (1) энэ зүйлийн (a)-д заасан аль ч барааг нээн шалгаж болно;
- (2) сорилт, дүн шинжилгээ хийх болон нотлох баримт болгох зорилгоор **агууламжийн** дээжийг авч болно.

В Бүлэг — Баглаа Боодол, Савлагаа, Тэмдэглэгээ Болон Шошго**92.51. Баглаа боодолд тавих шаардлага**

(a) Этгээд нь тухайн баглаа боодол дараах шаардлагыг хангаснаас бусад тохиолдолд, энэ Дүрмийн шаардлага хангасан гэж тэмдэглэгээ хийх, шошго тавих, баталгаажуулах, эсхүл баглаа боодлыг санал болгохгүй:

- (1) Техникийн зааварчилгааны дагуу үйлдвэрлэсэн, бэлтгэсэн, тэмдэглэгээ хийсэн, үйлчилгээ хийсэн, нөхцөлийг сайжруулсан болон засварласан (аль тохирохоор);
- (2) Техникийн зааварчилгааны дагуу сорилт хийсэн;
- (3) Монгол Улсад үйлдвэрлэсэн баглаа боодлын хувьд:
 - (i) итгэмжлэгдсэн эрх бүхий байгууллагаар сорилт хийгдсэн;
 - (ii) 7-р ангиллын аюултай барааны баглаа боодлоос бусад баглаа боодол нь Даргаар зөвшөөрөгдсөн;
 - (iii) 7-р ангиллын аюултай барааны баглаа боодлын хувьд, үндэсний цацраг идэвхт материалын лабораториор зөвшөөрөгдсөн.
- (4) Монгол Улсад үйлдвэрлээгүй баглаа боодлын хувьд, Хэлэлцэн тохирогч Улсад үйлдвэрлэсэн ба сорилт хийсэн байх.

(b) Энэ зүйлийн (a)(3) болон (4) нь Техникийн зааварчилгаанд сорилт хийсэн байхыг шаардаагүй баглаа боодолд хамаарахгүй.

92.53. Баглаа боодлын зөвшөөрөл

(a) Энэ дүрмийн 92.51(a)(3)(ii)-ын дагуу зөвшөөрөл хүсэх, эсхүл зөвшөөрөл сунгуулах хүсэлтийг Техникийн зааварчилгааны дагуу баглаа боодлын үзүүлэлтийн сорилтын тайлангийн хамт Даргад хүргүүлснээр гаргах ёстой.

(b) Энэ зүйлийн (a)-д заасан зөвшөөрлийг олгож болно, хэрэв:

- (1) тухайн баглаа боодлын үзүүлэлтийн сорилтын тайлан амжилттай үр дүн харуулж байгаа бол;
- (2) тухайн хүсэлт гаргагч нь дүрэмд заасан зохих хураамжийг төлсөн бол.

(с) Энэ зүйлийн (b)-ийн дагуу олгосон зөвшөөрлийг:

- (1) 5 хүртэлх жилийн хугацаагаар олгож, эсхүл сунгаж болно;
- (2) хугацаа дуусах, эсхүл хүчингүй болгох хүртэл хүчинтэй хэвээр байна;
- (3) Техникийн зааварчилгааны дагуу тухайн баглаа боодолд байрлуулах тэмдэглэгээг зааж өгнө.

92.55. Савлагаанд тавих шаардлага

Агаараар тээвэрлэх аюултай барааг савлаж буй этгээд бүр нь:

- (1) тухайн барааг Техникийн зааварчилгааны дагуу савлана;
- (2) Техникийн зааварчилгаанд өөрөөр зааснаас бусад тохиолдолд, тухайн баглаа боодолд дараахийг бататгана;
 - (i) холбогдох сорилтод заасны дагуу хэрэглэсэн болохыг;
 - (ii) савлагааны арга, түүний хэмжээ болон сорилт хийгдсэн аливаа дотоод баглаа боодлын төрлийг хамруулан, тухайн загварын маягтай бүх талаар нийцэж байгааг.

92.57. Тэмдэглэгээнд тавих шаардлага

Агаараар тээвэрлэх аюултай бараа агуулсан багц, эсхүл гадуур баглаа боодолд тэмдэглэгээ хийж буй этгээд нь тухайн багц, эсхүл гадуур баглаа боодолд тэмдэглэгээг дараах хэлбэрээр хийнэ:

- (1) Техникийн зааварчилгааны дагуу;
- (2) дараах байдлаар:
 - (i) аюултай барааны оноосон нэр болон, хэрэв тохиромжтой бол, техникийн нэрийг нэмэлтээр;
 - (ii) оноогдсон бол, хамаарах нэгдсэн үндэстний дугаар / **UN** үсгээр эхэлсэн/;
 - (iii) аюултай барааг агаараар тээвэрлүүлэхээр санал болгосон тухайн этгээдийн болон хүлээн авагчийн нэр, хаяг;
 - (iv) Техникийн зааварчилгаанд заасны дагуу бусад тэмдэглэгээ.

92.59. Шошгонд тавих шаардлага

Агаараар тээвэрлэх аюултай бараа агуулсан багц, эсхүл гадуур баглаа боодолд шошго тавьж байгаа этгээд нь дараах үүрэгтэй:

- (1) багц, гадуур баглаа боодол бүрт Техникийн зааварчилгааны дагуу шошго тавих;
- (2) аюулын шошго нэг бүр Техникийн зааварчилгааны дагуу тухайн аюулын жинхэнэ мөн чанарыг харуулж байгааг бататгах.

С Бүлэг — Аюултай барааг тээвэрлэлтэд санал болгох

92.101. Хамрах хүрээ

(a) Энэ Бүлэг нь аюултай барааг агаараар тээвэрлэхэд санал болгоход тавих шаардлагыг тогтооно.

(b) Аюултай барааг агаараар тээвэрлүүлэхээр санал болгож буй этгээдийн өмнөөс энэ Бүлэгт шаардсан үйл ажиллагааг гүйцэтгэж байгаа этгээд нь энэ Бүлгийн дагуу тухайн үйл ажиллагааг гүйцэтгэнэ.

92.103. Аюултай барааг тээвэрлэлтэд санал болгох

Аюултай бараа агуулсан багц, эсхүл гадуур баглаа боодлыг агаараар тээвэрлүүлэхээр санал болгож буй этгээд нь дараахийг бататгана:

- (1) тухайн аюултай барааг Техникийн зааварчилгааны дагуу агаараар тээвэрлэхэд хориглоогүй болохыг;
- (2) тухайн аюултай барааг энэ Бүлгийн дагуу баталгаажуулсан болохыг;
- (3) тухайн аюултай барааг В Бүлэгт заасан хэлбэрээр багцалсан, савласан, тэмдэглэгээ хийгдсэн болон шошго тавигдсан болохыг;
- (4) Техникийн зааварчилгаанд шаардсан бол, тухайн аюултай бараанд 92.105-ын дагуу бүрдүүлсэн ба гарын үсэг зурсан аюултай барааны тээврийн баримт бичиг дагалдуулсан болохыг;
- (5) тухайн бараа нь Техникийн зааварчилгааг өөр хэлбэрээр хангасан болохыг.

92.105. Аюултай барааны тээврийн баримт бичиг

(a) Аюултай барааг агаараар тээвэрлүүлэхээр санал болгож буй аливаа этгээд нь 92.103(4)-г харгалзан, 2 хувь үйлдэж, гарын үсэг зурсан дараах аюултай барааны тээврийн баримт бичгийг тухайн үйл ажиллагаа эрхлэгчид хүргүүлнэ:

- (1) дараах дарааллаар тухайн аюултай барааг зөв дүрсэлсэн:
 - (i) ачааны оноосон нэр;
 - (ii) ангилал, эсхүл тогтоосон бол, Ангилал 1-ийн хувьд, нийцлийн группыг багтаасан бүлэг (division);
 - (iii) хэрэв байгаа бол, нэгдсэн үндэстний дугаарыг UN үсгээр эхэлсэн UN дугаар;
 - (iv) тогтоосон бол, тохирох савлагааны групп;
- (2) аюултай барааг агаараар тээвэрлүүлэхээр санал болгож буй этгээд гарын үсэг зурсан дараах мэдэгдлийг агуулсан:

Би энэ илгээх барааны агууламжийг оноосон нэрээр бүрэн гүйцэт, нягт нямбай тодорхойлсон ба олон улсын болон үндэстний холбогдох хууль дүрэмд заасан тээвэрлэлтийн тохирох нөхцөлийн дагуу ангилсан,

багцалсан, савласан, тэмдэглэсэн ба шошго / зурагт хуудас тавьсан болохыг мэдэгдэж байна.

(3) Техникийн зааварчилгаанд заасан аливаа нэмэлт шаардлагыг хангасан;

(b) Энэ зүйлийн (a)(2)-т шаардсан мэдэгдэл нь холбогдох зурагт хуудсанд тусгагдсан ишлэлийг дурдахгүй байж болно.

D Бүлэг — Үйл ажиллагаа эрхлэгч

92.151. Хамрах хүрээ

(a) Энэ Бүлэг нь дараах үйл ажиллагаанд тавих шаардлагыг тогтооно:

(1) үйл ажиллагаа эрхлэгчийн аюултай барааг хүлээн авах, тээвэрлэлтэд бэлтгэх, хадгалах, ачаалах болон шалгах;

(2) үйл ажиллагаа эрхлэгч аюултай барааны талаар мэдээллээр хангах.

(b) Үйл ажиллагаа эрхлэгчийн өмнөөс энэ Бүлэгт шаардсан үйл ажиллагааг гүйцэтгэж буй этгээд нь энэ Бүлгийн дагуу тухайн үйл ажиллагааг гүйцэтгэнэ.

(c) Энэ Бүлэгт үйл ажиллагаа эрхлэгчийг тухайн эд зүйл, эсхүл бодис заавал тээвэрлэх шаардлагатай гэж, эсхүл үйл ажиллагаа эрхлэгчийг тухайн эд зүйл, эсхүл бодис тээвэрлэхэд тавих тусгай шаардлагаас чөлөөлнө гэж тайлбарлаагүй.

92.153. Аюултай бараа хүлээн авах

Үйл ажиллагаа эрхлэгч нь багц, гадуур баглаа боодол, эсхүл Техникийн зааварчилгаанд зөвшөөрсөн бол, аюултай барааг агуулсан ачилтын нэгж төхөөрөмжийг дараахаас бусад тохиолдолд агаараар тээвэрлэхээр хүлээн авахгүй:

(1) Техникийн зааварчилгаанд тухайн баримт бичгийг шаардлагагүй гэж зааснаас бусад тохиолдолд, 92.105-д заасан аюултай барааны тээврийн баримт бичгийн 2 хувийг дагалдуулсан;

(2) тухайн багц, гадуур баглаа боодол, эсхүл ачилтын нэгж төхөөрөмж нь:

(i) 92.163-ын дагуу үзлэг хийгдсэн;

(ii) 92.57 болон 92.59-ийн дагуу тэмдэглэгээ хийж, шошго зүүсэн.

92.155. Хүлээн авах шалгалт

Агаараар тээвэрлэх аюултай барааг хүлээн авч байгаа үйл ажиллагаа эрхлэгч нь:

(1) дараахийг бататгах хүлээн авах шалгах хуудсыг ашиглана:

(i) 92.153-ын шаардлага хангагдсан болохыг;

(ii) тухайн аюултай барааны тээврийн баримт бичиг нь 92.105-ын шаардлагыг хангасан болохыг.

(2) хүлээн авах шалгалтын үр дүнгийн бүртгэлийг хөтөлнө;

- (3) энэ хэсгийн (2)-т шаардсан бүртгэлийг 6-аас доошгүй сарын хугацаанд хадгална.

92.157. Агаарын хөлөгт ачаалах хязгаарлалт

(a) Энэ зүйлийн (b)-д зааснаас бусад тохиолдолд, үйл ажиллагаа эрхлэгч нь аюултай барааг зорчигчтой агаарын хөлгийн бүхээгт, эсхүл агаарын хөлгийн нислэгийн бүхээгт тээвэрлэхгүй.

(b) Үйл ажиллагаа эрхлэгч нь:

- (1) хэрэв Техникийн зааварчилгаанд хийхийг зөвшөөрсөн бол, зорчигч, эсхүл нисэх багийн гишүүнийг, үзлэг хийгдсэн ачаа, эсхүл гар тээшинд, эсхүл биедээ аюултай бараа авч орохыг зөвшөөрч болно;
- (2) хэрэв Техникийн зааварчилгаанд тусгайлсан багцаар хийхийг зөвшөөрсөн бол, цацраг идэвхт материалыг зорчигчтой агаарын хөлгийн бүхээгт, эсхүл агаарын хөлгийн нислэгийн бүхээгт тээвэрлэхийг зөвшөөрч болно;
- (3) тухайн агаарын хөлөг В ангиллын ачааны тасалгаагаар тоноглогдоогүй үед, орон нутгийн нислэг үйлдэх бол, дараах аюултай барааг зорчигчийн бүхээгийн ачааны хэсэгт тээвэрлэж болно:
 - (i) Ангилал 1, Бүлэг 1.4 Групп S -д хамаарах тэсрэмтгий бодис;
 - (ii) Ангилал 2, Бүлэг 2.2, шатамхай бус, хоргүй хий;
 - (iii) Ангилал 3, шатамхай шингэн /савлагааны Групп– III/;
 - (iv) Ангилал 4, Бүлэг 4.1- шатамхай хатуу бодис / савлагааны Групп – III/;
 - (v) Ангилал 5, Бүлэг 5.1- исэлдэгч бодис / савлагааны Групп – III/;
 - (vi) Ангилал 6, Бүлэг 6.1- хортой бодис / савлагааны Групп – III/;
 - (vii) Ангилал 7, минимум тусгаарлах зайг ханган ачсан цацраг идэвхт материал;
 - (viii) Ангилал 8, савлагааны Групп – III бодис;
 - (ix) Ангилал 9, бусад бараа.

(c) Үйл ажиллагаа эрхлэгч нь хэрэв тухайн тасалгаа нь В ангиллын ачаа, эсхүл тээшний тасалгаанд тавих бүх гэрчилгээжүүлэлтийн шаардлагыг хангаж байгаа бол, агаарын хөлгийн зорчигч тээвэрлэж буй үндсэн ачааны тасалгаанд аюултай барааг тээвэрлэж болно.

(d) Агаараар тээвэрлэх аюултай барааг хүлээн авч байгаа үйл ажиллагаа эрхлэгч бүр нь “Зөвхөн ачааны агаарын хөлөг” гэсэн шошготой аюултай барааны багцыг ачааны агаарын хөлөгт ачна.

92.159. Хоорондоо үл зохицох аюултай бараа

Агаараар тээвэрлэх аюултай барааг хүлээн авч байгаа үйл ажиллагаа эрхлэгч нь хоорондын харилцан үйлчлэлээр аюултай нөхцөл байдал үүсгэж болох аюултай бараа агуулсан багцыг, гоожсон тохиолдолд хоорондоо урвалд орж болох байрлалд, эсхүл хамт зэрэгцүүлэн байрлуулахгүй.

92.161. Ялгах, тусгаарлах, аюулгүй байдлыг хамгаалах

Агаараар тээвэрлэх аюултай бараа хүлээж авч байгаа үйл ажиллагаа эрхлэгч бүр нь:

- (1) хортой болон халдварт бодис агуулсан багцыг Техникийн зааварчилгааны дагуу байрлуулна;
- (2) цацраг идэвхт материалыг хүн, амьтан болон боловсруулаагүй гэрэл зураг, киноны хальснаас тусад нь Техникийн зааварчилгааны дагуу байрлуулна;
- (3) агаарын хөлөгт ачсан тухайн аюултай барааг гэмтэхээс хамгаална;
- (4) аюултай барааг агаарын хөлөгт тухайн багцын байрлалыг өөрчилж болох нислэгийн аливаа хөдөлгөөнөөс сэргийлэх хэлбэрээр бэхэлнэ.

92.163. Ачаалах үеийн хяналт

Үйл ажиллагаа эрхлэгч нь:

- (1) дараахаас бусад тохиолдолд, агаарын хөлөгт, эсхүл ачилтын нэгж төхөөрөмжид аюултай бараа агуулсан багц, эсхүл гадуур баглаа боодлыг ачихгүй:
 - (i) тухайн ачилтын өмнөх үзлэг хийгдсэн;
 - (ii) гоожсон, эсхүл гэмтсэн нотолгоо байхгүй;
- (2) ачилтын нэгж төхөөрөмж дараах шаардлагыг хангах хүртэл агаарын хөлөгт тухайн төхөөрөмжийг ачихгүй:
 - (i) тухайн ачилтын өмнөх үзлэг хийгдсэн;
 - (ii) түүнд агуулагдсан аливаа аюултай бараа гоожсон, эсхүл гэмтсэн нотолгоо байхгүй.

92.165. Буулгах үеийн хяналт

Аюултай бараа агуулсан багц, эсхүл гадуур баглаа боодол тээвэрлэж байгаа үйл ажиллагаа эрхлэгч нь агаарын хөлгөөс, эсхүл ачилтын нэгж төхөөрөмжөөс тухайн багц, эсхүл гадуур баглаа боодлыг буулгаж байхдаа гоожсон, эсхүл гэмтсэн шинж тэмдэг байгаа эсэхийг шалгана.

92.167. Гэмтэл, эсхүл бохирдлыг цэвэрлэх

Агаарын хөлгөөс ачаа буулгах үед гэмтсэн, эсхүл гоожсон нотолгоо олж тогтоосон бол, тухайн үйл ажиллагаа эрхлэгч нь:

- (1) тухайн аюултай бараа, эсхүл ачилтын нэгж төхөөрөмж байрлаж байсан агаарын хөлгийн тухайн хэсгийн гэмтэл, эсхүл бохирдлыг шалгана;
- (2) аливаа аюултай бохирдлыг цэвэрлэнэ.

92.169. Халдварт бодис

Агаарын хөлөгт ачсан халдварт бодис агуулсан аливаа багц гэмтсэн, эсхүл гоожсон байдалтай байгаа бол, тухайн үйл ажиллагаа эрхлэгч нь:

- (1) тухайн багцыг оролдохоос зайлсхийх, эсхүл аль болох бага хөндөнө;
- (2) зэргэлдээх багцын бохирдлыг шалгах болон бохирдсон байж болох багцыг тусад нь тавина;
- (3) тухайн холбогдох эрүүл мэндийн эрх бүхий байгууллага, эсхүл мал эмнэлгийн эрх бүхий байгууллагад мэдэгдэх ба хүмүүст аюул учруулсан байж болох дамжин өнгөрсөн бусад орнуудад мэдээлэл хүргүүлнэ;
- (4) тухайн илгээгч, эсхүл хүлээн авагчид мэдэгдэнэ.

92.171. Цацраг идэвхт материал

Агаарын хөлөг цацраг идэвхт материалаар бохирдсон бол, агаараар цацраг идэвхт материал тээвэрлэж байгаа үйл ажиллагаа эрхлэгч бүр нь:

- (1) тухайн агаарын хөлгийг үйлчилгээнээс яаралтай гаргаж зогсооно;
- (2) аливаа хүрч болох гадаргуун цацрагийн түвшин болон бохирдлын үлдэгдэл нь Техникийн зааварчилгаанд заасан хэмжээнээс хэтрэхгүй болж багасах хүртэл тухайн агаарын хөлгийг үйлчилгээнд эргүүлэн гаргахгүй.

92.173. Хөлгийн даргыг мэдээллээр хангах

(a) Аюултай бараа тээвэрлэх үйл ажиллагаа эрхлэгч бүр нь тухайн агаарын хөлөг нисэн гарахаас өмнө, тухайн агаарын хөлгийн даргад Техникийн зааварчилгааны дагуу тухайн аюултай бараатай холбоотой мэдээллийг бичгээр хүргүүлнэ.

(b) Үйл ажиллагаа эрхлэгч нь энэ зүйлийн (a)-д заасан мэдээлэл дараах шаардлага хангаж байгааг бататгана:

- (1) тухайн нислэгийн үед хөлгийн дарга ашиглахад бэлэн байх;
- (2) зориулагдсан маягтаар танилцуулсан байх.

(c) Энэ дүрмийн 92.105-ын дагуу аюултай барааны тээврийн баримт бичиг бүрдүүлсэн байхыг шаарддаг аюултай бараа тээвэрлэж байгаа үйл ажиллагаа эрхлэгч бүр, тухайн агаарын хөлөг нисэн гарахаас өмнө, агаарын хөлгийн даргыг тухайн тээвэрлэж байгаа аюултай бараатай холбоотой осол, зөрчлийн үед ашиглах онцгой нөхцөлийн хариу арга хэмжээний мэдээллээр хангана.

(d) Тухайн үйл ажиллагаа эрхлэгч нь энэ зүйлийн (c)-д шаардсан мэдээллийг тухайн нислэгийн үед хөлгийн дарга ашиглахад бэлэн байлгана;

(e) Тухайн үйл ажиллагаа эрхлэгч нь энэ зүйлийн (c)-д шаардсан мэдээлэл нь дараах баримт бичгийн дагуу хүргүүлсэн болохыг бататгана:

- (1) хүчин төгөлдөр ИCAO-гийн Док.9481 Аюултай бараатай холбоотой агаарын хөлгийн зөрчлийн авах онцгой нөхцөлийн хариу арга хэмжээний зааварчилгаа; эсхүл
- (2) тухайн тээвэрлэж байгаа аюултай бараатай холбоотой ижил төстэй мэдээллээр хангадаг бусад баримт бичиг.

92.175. Ажилтныг мэдээллээр хангах

Үйл ажиллагаа эрхлэгч бүр нь өөрийн ажилтан болон хамааралтай бол, тэдний үйлчилгээний агентыг аюултай барааны тээвэрлэхтэй холбоотой үүрэг хариуцлагаа хэрэгжүүлэхэд шаардлагатай дараах мэдээллээр хангана:

- (1) аюултай бараатай холбоотой үүссэн онцгой нөхцөлийн үед авах арга хэмжээний зааварчилгаа;
- (2) Техникийн зааварчилгаанд тусгасан бусад мэдээллийг багтаасан.

92.177. Бараа хүлээн авах байрлалын мэдээлэл

(a) Үйл ажиллагаа эрхлэгч бүр нь аюултай барааны тээвэрлэлтийн талаар мэдээллийг олон нийтэд хүргэх анхааруулгыг ачаа хүлээн авах байрлалд байрлуулна.

(b) Энэ зүйлийн (a)-ийн анхааруулга нь:

- (1) хүрэлцэхүйц тоотой байна;
- (2) ил харагдахуйц хэлбэрээр байрлуулсан байна.

92.179. Зорчигчийг мэдээллээр хангах

(a) Үйл ажиллагаа эрхлэгч нь агаарын хөлөгт авч орохыг хориглосон барааны төрлийг зорчигчид мэдээлэх үүрэгтэй.

(b) Энэ зүйлийн (a)-д шаардсан мэдээллийг дараах байдлаар хүргэсэн байх ёстой:

- (1) хүрэлцэхүйц тоо хэмжээтэй ба ил харагдахуйц дараах байрлалд байрлуулсан анхааруулгаар:
 - (i) зорчигчийн тийз олгох болон тээш бүртгүүлэх байрлал бүрт;
 - (ii) агаарын хөлөгт зорчигч орох талбай бүрт.
- (2) зорчигчийн тийзэнд, хэрэв бодит-тийз биш бол, суудал захиалгын баталгааны хэсэг хэлбэрээр.

92.181. Үйл ажиллагаа эрхлэгчээр саатуулагдах

Үйл ажиллагаа эрхлэгч 92.17-ийн дагуу Дарга саатуулсанд тооцогдох аюултай барааг мэдэлдээ байлгаж байгаа бол, тухайн үйл ажиллагаа эрхлэгч нь:

- (1) тухайн барааг Дарга өөрийн мэдэлд авах хүртэл барааг аюулгүй хадгалах бүх боломжит урьдчилан сэргийлэх арга хэмжээг авна;
- (2) тухайн барааг Дарга үзлэг, сорилт, дүн шинжилгээ хийх, эсхүл нотолгоо болгох зорилгоор цаашид шаардлагагүй гэж мэдэгдсэн бол, саатуулагдсан барааг чөлөөлж болно.

Е Бүлэг — Сургалт**92.201. Хамрах хүрээ**

Энэ Бүлэг дараах этгээдийн аюултай барааны сургалтад тавих шаардлагыг тогтооно:

- (1) аюултай барааг тогтмол илгээгч болон түүний үйлчилгээний агент;
- (2) агаараар тээвэрлэх аюултай барааг хүлээн авах үйл ажиллагаа эрхлэгч;
- (3) агаараар тээвэрлэх аюултай барааг хүлээн авах үйлчилгээний агент;
- (4) зорчигч, эсхүл ачааг агаараар тээвэрлэдэг, эсхүл бэлтгэх ажиллагаанд оролцдог үйл ажиллагаа эрхлэгчээс бусад агентлаг, байгууллага болон этгээд;
- (5) зорчигч болон түүний тээшинд аюулгүй байдлын үзлэг шалгалт хийдэг агентлаг.

92.203. Аюултай барааны сургалтын хөтөлбөр

(а) ИНД-119-ийн дагуу олгосон агаарын тээвэрлэгчийн гэрчилгээ эзэмшигч, эсхүл гэрчилгээ эзэмшигчийн үйлчилгээний агент, агаараар тээвэрлэхээр зорьж байгаа аюултай бараатай холбоотой үүрэг гүйцэтгэхээр томилогдсон ажилтан нь дараах байгууллагын зохион байгуулсан Хавсралт А-ийн дагуу 92.205-д заасан давтан сургалтыг багтаасан аюултай барааны сургалтын хөтөлбөрийг амжилттай төгссөн болохыг бататгах үүрэгтэй:

- (1) ИНД-119-ийн дагуу олгосон агаарын тээвэрлэгчийн гэрчилгээ эзэмшигч, хэрэв тухайн гэрчилгээ нь аюултай барааны сургалт зохион байгуулахыг зөвшөөрсөн бол; эсхүл
- (2) ИНД-141-ийн дагуу олгосон нисэхийн сургалтын байгууллагын гэрчилгээ эзэмшигч, хэрэв тухайн гэрчилгээ нь аюултай барааны сургалт зохион байгуулахыг зөвшөөрсөн бол.

(b) Агаарын тээвэрлэгчийн гэрчилгээ эзэмшигч, эсхүл тухайн гэрчилгээ эзэмшигчийн үйлчилгээний агентаас бусад этгээд нь агаараар тээвэрлэхээр зорьж байгаа аюултай бараатай холбоотой үүрэг гүйцэтгэхээр томилогдсон ажилтан дараах эзэмшигчийн зохион байгуулсан, хэрэв хамааралтай бол, Хавсралт А-ийн дагуу 92.205-д заасан

давтан сургалтыг багтаасан аюултай барааны сургалтын хөтөлбөрийг амжилттай төгссөн болохыг бататгах үүрэгтэй:

- (1) ИНД-141-ийн дагуу олгосон нисэхийн сургалтын байгууллагын гэрчилгээ, хэрэв тухайн гэрчилгээ нь аюултай барааны сургалт зохион байгуулахыг зөвшөөрсөн бол; эсхүл
- (2) олон улсын агаарын тээвэрлэгчдийн холбооны аюултай барааны сургалтын хөтөлбөрийн хүчинтэй итгэмжлэгдсэн гэрчилгээ.

(с) Гадаад улсад үйл ажиллагаа явуулж байгаа Монгол Улсын бүртгэлтэй агаарын хөлгийн үйл ажиллагаа эрхлэгчийг, хэрэв агаарын хөлөгт ачих болон буулгах үйл ажиллагааг тухайн улсын дараах ажилтан гүйцэтгэж байгаа бол, энэ зүйлийн (а)-г дагаж мөрдөхийг шаардахгүй:

- (1) 92.203-ын дагуу тухайн сургалтын шаардлагыг хангасан этгээд хяналт тавьж байгаа; эсхүл
- (2) тухайн Улсын шаарддаг аюултай барааны сургалтыг хөтөлбөрийг амжилттай төгссөн; эсхүл
- (3) дараах байгууллагын зохион байгуулсан аюултай барааны сургалтын хөтөлбөрийг амжилттай төгссөн:
 - (i) олон улсын агаарын тээвэрлэгчдийн холбооны эйрлайны гишүүн өөр үйл ажиллагаа эрхлэгч; эсхүл
 - (ii) олон улсын агаарын тээвэрлэгчдийн холбооны, аюултай барааны сургалт хөтөлбөрийн хүчинтэй итгэмжлэгдсэн гэрчилгээ эзэмшигч.

(d) Монгол Улсад үйл ажиллагаа явуулж байгаа Гадаад Улсын бүртгэлтэй агаарын хөлгийн үйл ажиллагаа эрхлэгч, эсхүл үйлчилгээний агентыг, хэрэв аюултай бараатай холбоотой ажил үүрэг гүйцэтгэх ажилтан нь агаарын хөлгийн бүртгэгч Улсын шаарддаг аюултай барааны сургалтын хөтөлбөрийг амжилттай төгссөн бол, энэ зүйлийн (а)-г дагаж мөрдөхийг шаардахгүй.

92.205. Давтан сургалт

Энэ дүрмийн 92.203-д шаардсан аюултай барааны сургалтын хөтөлбөрийг төгссөн этгээд бүр нь:

- (1) тухайн хөтөлбөрийг төгссөнөөс хойш 2 жилийн дотор, аюултай барааны давтан сургалтын хөтөлбөрт хамрагдана;
- (2) 2 жилээс хэтрэхгүй хугацааны давтамжтайгаар аюултай барааны давтан сургалтын хөтөлбөрт дахин хамрагдана.

92.207. Ажилтны хувийн хэрэг

(а) Энэ Дүрэм үйлчлэх этгээд бүр нь аюултай бараатай холбоотой ажил үүргийг гүйцэтгэхээр томилогдсон ажилтан нэг бүрийн хувийн хэргийг тэдний ажиллаж байгаа бүх хугацааны турш хадгална.

(b) Энэ зүйлийн (a)-ийн дагуу хадгалах шаардлагатай хувийн хэрэгт ажилтан нэг бүрийн дараах мэдээллийг тусгасан байна:

- (1) хамрагдсан анхан шатны сургалтын хөтөлбөр болон сүүлийн давтан сургалт;
- (2) сургалтанд хамрагдсан он сар өдөр;
- (3) сургалтыг зохион байгуулсан этгээдийн болон байгууллагын нэр;
- (4) сургалтаар олж авсан ур чадвар болон дүн.

Хавсралт А — Аюултай барааны сургалтын хөтөлбөр

Аливаа этгээдийн хамрагдсан аюултай барааны сургалтын хөтөлбөр нь тухайн этгээдэд оногдох аюултай бараатай холбоотой ажил үүрэгт тохирсон байх ба дараах сургалтыг багтаана:

- (1) ерөнхий танилцах сургалт – ерөнхий заалттай танилцуулах зорилготой;
- (2) үйл ажиллагааны-тусгай сургалт- тухайн хүний хариуцах үйл ажиллагаанд холбогдох шаардлага бүрийг нарийвчлан өгөх сургалт;
- (3) аюулгүй ажиллагааны сургалт-тухайн аюултай бараанаас үүдэлтэй аюул, аюулгүй ажиллах болон онцгой нөхцөлийн үед авах арга хэмжээний журмыг багтаасан;
- (4) дараах холбогдох сэдвийн сургалт:

Хамрагдах ажилтан	Сэдэв
Үйл ажиллагаа эрхлэгчийн хүлээн зөвшөөрөх ажилтан	Монгол Улсын хууль, дүрэм; аюултай барааны ангилал; хориг; савлах зааварчилгаа; шошго болон таних тэмдэг тавих; аюултай барааны тээврийн баримт бичиг үйл ажиллагааг эрхлэгчийн хариуцлага; илгээгчийн хариуцлага; онцгой нөхцөлийн журам
Аюултай барааны газрын үйлчилгээний хадгалалт болон ачилтад оролцдог ажилтан	Ерөнхий философи; шошго болон таних тэмдэг тавих; тээвэрлэх болон ачих журам; хоорондын нийцэл; онцгой нөхцөлийн журам
Зорчигч үйлчилгээний ажилтан болон зорчигч болон ачаа тээшинд аюулгүй үзлэг хийх аюулгүй байдлын хамгаалалтын ажилтан	Ерөнхий философи; Монгол Улсын хууль, дүрэм; хориотой аюултай бараа; зорчигчид үл хамаарах; шошгоны ерөнхий таних тэмдэг
Нисэх багийн гишүүд	Ерөнхий философи; Монгол Улсын хууль, дүрэм; шошго болон таних тэмдэг тавих; нисгэгчид мэдээлэх; онцгой нөхцөлийн журам; хоорондын нийцэл; ачих журам
Нисэх багийн гишүүдээс бусад багийн гишүүд	Ерөнхий философи; Монгол Улсын хууль, дүрэм; хориотой аюултай бараа; зорчигчид үл хамаарах; шошгоны ерөнхий таних тэмдэг; онцгой нөхцөлийн журам
Баглаа боодолчин	Аюултай барааны ангилал; аюултай барааны жагсаалт; таних тэмдэг тавих ерөнхий шаардлага; дүйцэх шаардлага; таних тэмдэг тавих тусгай зааварчилгаа; шошго болон таних тэмдэг тавих
Тогмол илгээгч болон түүний үйлчигээний агент	Аюултай барааны ангилал; хориотой аюултай барааны жагсаалт; таних тэмдэг тавих зааварчилгаа; шошго болон таних тэмдэг тавих; илгээгчийн хариуцлага; аюултай барааны тээврийн баримт бичиг

--oOo--